



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газар ОНӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/030/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Даланзадгад хот

2026 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа

Утас: 70533552 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn

Аудитор: Э.Жаргал

Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 295
танай _____-ны № _____-г

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН "НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР"
ОНӨҮГ-ЫН ДАРГА Б.УЛАМЦЭНГЭЛ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөговь аймгийн "Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газар" ОНӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд анхан шатны баримтаар нотлогдохгүй ажил гүйлгээ санхүүжүүлсэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, нөхөн олговор давхардуулан олгосон, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, эд хөрөнгө ашиглалтын бүртгэлийг шинэчилж баталгаажуулаагүй, эд хариуцагчийн гэрээ байгуулаагүй зэрэг нийт 32,168.5 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1, 71.1.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 5/20 дугаар тогтоолоор 1,452,821.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

4626050496

УС-ын цахим хуудас: www.audit.mn

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u>	4	-	<u>2,748,960.00</u>
Банканд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		-	<u>2,748,960.00</u>
Төгрөг		-	<u>2,748,960.00</u>
Төрийн сангийн харилцах			2,748,960.00
<u>АВЛАГА</u>	5	<u>997,000.00</u>	<u>13,121,841.14</u>
Ажиллагчидтай холбогдсон		-	353,241.00
Төлбөртэй үйлчилгээний авлага		997,000.00	1,577,000.00
Хувь хүмүүсээс авах авлага		-	11,191,600.14
<u>БАРАА МАТЕРИАЛ</u>	6	<u>1,913,800.00</u>	<u>5,972,400.00</u>
Хангамжийн материал		1,913,800.00	5,972,400.00
Хүнсний материал		1,913,800.00	-
Бусад хангамжийн материал		-	5,972,400.00
<u>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</u>		<u>2,910,800.00</u>	<u>21,843,201.14</u>
<u>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</u>		<u>337,476,510.45</u>	<u>1,519,300,516.21</u>
<u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u>	7	<u>337,476,510.45</u>	<u>1,519,300,516.21</u>
<u>Биет хөрөнгө</u>		<u>337,476,510.45</u>	<u>1,502,050,516.21</u>
Барилга, байгууламж, орон сууц		76,781,470.84	1,342,694,263.62
Хуримтлагдсан элэгдэл		(8,799,714.96)	(175,827,425.40)
Авто-тээврийн хэрэгсэл		39,250,000.00	100,368,116.23
Хуримтлагдсан элэгдэл		(31,562,500.35)	(34,468,418.60)
Машин, тоног төхөөрөмж /компьютер/		397,464,300.00	357,422,193.84
Хуримтлагдсан элэгдэл		(249,335,101.88)	(208,561,434.14)
Тавилга, аж ахуйн эд хогшил		77,583,809.72	142,038,214.87
Хуримтлагдсан элэгдэл		(30,250,819.64)	(76,658,771.04)
Бусад үндсэн хөрөнгө		117,192,000.00	108,124,693.78
Хуримтлагдсан элэгдэл		(50,846,933.28)	(53,080,916.95)
<u>Биет бус хөрөнгө</u>		<u>-</u>	<u>17,250,000.00</u>
Программ хангамж		-	1,237,500.00
Хуримтлагдсан элэгдэл		-	(1,237,500.00)
Бусад биет бус хөрөнгө			17,250,000.00
<u>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</u>		<u>337,476,510.45</u>	<u>1,519,300,516.21</u>
<u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u>		<u>340,387,310.45</u>	<u>1,541,143,717.35</u>
Богино хугацаат өр төлбөр		-	<u>647,609.00</u>
Өглөг	9	-	<u>647,609.00</u>
Хувь хүмүүст төлөх өглөг		-	647,609.00
<u>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u>		<u>-</u>	<u>647,609.00</u>
<u>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u>		<u>-</u>	<u>647,609.00</u>
<u>Засгийн газрын хувь оролцоо</u>		<u>340,387,310.45</u>	<u>1,540,496,108.35</u>
<u>Хуримтлагдсан үр дүн</u>		<u>340,387,310.45</u>	<u>1,540,496,108.35</u>
Өмнөх үеийн үр дүн		340,387,310.45	340,387,310.45
Тайлант оны үр дүн			1,200,108,797.90
<u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</u>		<u>340,387,310.45</u>	<u>1,540,496,108.35</u>

ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		340,387,310.45	1,541,143,717.35
--	--	-----------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		819,725,878.93	3,158,221,562.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих		819,725,878.93	3,158,221,562.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжих/Орон нутаг/		640,000,000.00	2,721,823,700.00
ЗДТХөрөнгө түүнтэй адилтгах нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		42,200,000.00	396,176,362.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		137,525,878.93	40,221,500.00
Төсөв байгууллагын өөрийн орлого		373,851,427.47	1,452,167,676.90
Төсөв байгууллагын өөрийн орлого		52,305,260.00	173,168,133.19
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө		321,546,167.47	1,273,027,143.71
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал			5,972,400.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	1,193,577,306.40	4,610,389,238.90
УРСГАЛ ЗАРДАЛ		718,384,975.76	3,410,280,441.00
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ		484,860,090.68	3,270,477,563.22
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ		381,036,480.26	2,827,110,814.62
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		340,764,908.71	2,535,862,215.06
Үндсэн цалин		119,793,620.09	1,040,037,329.45
Нэмэгдэл		145,908,088.62	1,035,778,570.82
Унаа хоолны хөнгөлөлт		15,239,000.00	109,512,052.68
Урамшуулал		59,824,200.00	350,534,262.11
Нийгмийн хамгааллын шимтгэл		40,271,571.55	291,248,599.56
Тэтгэврийн даатгал		28,210,117.32	202,655,139.50
Тэтгэмжийн даатгал		3,547,055.92	25,619,491.99
ҮОМШӨ-ний даатгал		1,747,127.97	12,640,292.81
Ажилгүйдлийн даатгал		1,353,454.06	10,066,735.00
Эрүүл мэндийн даатгал		5,413,816.28	40,266,940.26
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		-	71,723,600.90
Гэрэл, цахилгаан			11,974,612.46
Түлш, халаалт			54,927,064.44
Цэвэр, бохир ус			4,821,924.00
Хангамж, бараа материалын зардал		6,003,760.00	35,411,727.00
Бичиг хэрэг		-	2,539,150.00
Тээвэр, шатахуун		-	1,240,600.00
Шуудан холбоо, интернэтийн төлбөр		325,360.00	10,001,827.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		-	348,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,678,400.00	21,282,150.00
Нормативд зардал		26,306,668.00	149,530,009.55
Хоол, хүнс		26,306,668.00	140,830,009.55
Нормын хувцас, зөөлөн эдлэл		-	8,700,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		50,419,527.00	9,921,300.00
Урсгал зардал		50,419,527.00	9,921,300.00
Томиллол, зочны зардал		-	820,000.00
Дотоод албан томиллолт		-	820,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		-	1,339,713.20
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		-	1,339,713.20
Бараа үйлчилгээний бусад зардал		21,093,655.42	174,620,397.95
Бараа үйлчилгээний бусад зардал		3,585,400.00	50,645,900.00

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		100,000.00	1,640,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		17,408,255.42	122,334,497.95
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		233,524,885.08	139,802,877.78
Бусад урсгал шилжүүлэг		15,522,000.00	62,075,057.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		15,522,000.00	17,762,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		-	44,313,057.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт		218,002,885.08	77,727,820.78
төвлөрүүлэх шилжүүлэг		218,002,885.08	77,727,820.78
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3	718,384,975.76	3,410,280,441.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		475,192,330.64	1,200,108,797.90
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)		7,015,161.60	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		7,015,161.60	-
Хөрөнгө худалдсаны гарз		7,015,161.60	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		(7,015,161.60)	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		468,177,169.04	1,200,108,797.90

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1,011,575,844.91	3,311,559,701.19
Татварын бус орлого	191,849,965.98	153,338,139.19
нийтлэг татварын бус орлого	191,849,965.98	153,338,139.19
төсөвт байгууллагын өөрийн орлого	89,966,550.00	153,338,139.19
үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		150,625,232.00
туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	89,966,550.00	2,712,907.19
Бусад орлого	101,883,415.98	
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	819,725,878.93	3,158,221,562.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	179,725,878.93	436,397,862.00
ЗДТХөрөнгө түүнтэй адилтгах нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,200,000.00	396,176,362.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	137,525,878.93	40,221,500.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	640,000,000.00	2,721,823,700.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	640,000,000.00	2,721,823,700.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,011,575,844.91	3,311,559,701.19
УРСГАЛ ЗАРДАЛ	975,791,844.91	3,296,929,375.19
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	975,791,844.91	3,296,929,375.19
Ажиллагчидтай холбогдсон зардал	622,751,951.33	2,838,008,046.76
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	567,967,501.91	2,545,415,936.07
Цалин	275,692,186.95	1,049,591,050.46
Нэмэгдэл	209,785,114.96	1,035,778,570.82
Унаа хоолны хөнгөлөлт	22,666,000.00	109,512,052.68
Урамшуулал	59,824,200.00	350,534,262.11
Нийгмийн хамгааллын шимтгэл	54,784,449.42	292,592,110.69
Тэтгэврийн шимтгэл	38,372,502.03	203,998,650.63
Тэтгэмжийн шимтгэл	4,826,647.69	25,619,491.99
ҮОМШӨ-ний даатгал	2,373,723.86	12,640,292.81
Ажилгүйдлийн даатгал	1,842,315.16	10,066,735.00
Эрүүл мэндийн даатгал	7,369,260.68	40,266,940.26

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	71,723,600.90
Гэрэл цахилгааны зардал	-	11,974,612.46
Түлш, халаалтын зардал	-	54,927,064.44
Цэвэр, бохир усны зардал	-	4,821,924.00
Хангамж, бараа материалын зардал	9,679,760.00	35,411,727.00
Бичиг хэргийн материал	-	2,539,150.00
Тээвэр, шатахууны зардал	-	1,240,600.00
Шуудан холбооны зардал	325,360.00	10,001,827.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	348,000.00
Бага үнэтэй түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	9,354,400.00	21,282,150.00
Нормативд зардал	55,656,121.50	147,616,209.55
Хоол	55,656,121.50	138,916,209.55
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал		8,700,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	50,447,527.00	9,921,300.00
Урсгал засварын зардал	50,447,527.00	9,921,300.00
Томилол, зочны зардал	-	820,000.00
Дотоод томилолтын зардал	-	820,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,339,713.20
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,339,713.20
Бараа үйлчилгээний бусад зардал	3,731,600.00	52,285,900.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3,631,600.00	50,645,900.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	100,000.00	1,640,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	233,524,885.08	139,802,877.78
Бусад урсгал шилжүүлэг	15,522,000.00	62,075,057.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	44,313,057.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	15,522,000.00	17,762,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	218,002,885.08	77,727,820.78
Төвлөрүүлэх шилжүүлэг	218,002,885.08	77,727,820.78
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	975,791,844.91	3,296,929,375.19
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	35,784,000.00	14,630,320.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV)	35,784,000.00	11,881,360.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	35,784,000.00	11,881,360.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)	(35,784,000.00)	(11,881,360.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)		2,748,960.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,748,960.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	(127,789,858.59)	(127,789,858.59)
Залруулсан үлдэгдэл	43,228,050.00	43,228,050.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Хөрөнгө оруулалтын өсөлт, бууралт	-	-

Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого	-	-
Тайлант үеийн үр дүн	468,177,169.04	468,177,169.04
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	340,387,310.45	340,387,310.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Хөрөнгө оруулалтын өсөлт, бууралт	-	-
Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого	-	-
Тайлант үеийн үр дүн	1,200,108,797.90	1,200,108,797.90
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,540,496,108.35	1,540,496,108.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,820,339,900.00	2,658,539,626.92	161,800,273.08	94.3
Орон нутгийн төсвөөс	2,820,339,900.00	2,658,539,626.92	161,800,273.08	94.3
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	290,411,000.00	142,489,173.19	150,634,728.00	49.1
үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	290,411,000.00	139,776,272.00	150,634,728.00	48.1
туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,712,901.19	-	1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,110,750,900.00	2,801,028,800.11	309,722,099.89	90.0
УРСГАЛ ЗАРДАЛ	3,110,750,900.00	2,801,028,800.11	309,722,099.89	90.0
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	2,986,521,500.00	2,747,053,743.11	239,467,756.89	92.0
Ажиллагчидтай холбогдсон зардал	2,587,809,400.00	2,506,629,832.46	81,179,567.54	96.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,300,275,000.00	2,248,672,945.86	51,602,054.14	97.8
Цалин	1,049,948,200.00	1,049,591,050.46	357,149.54	100.0
Нэмэгдэл	1,054,975,000.00	1,035,778,570.82	19,196,429.18	98.2
Унаа хоолны хөнгөлөлт	141,120,000.00	109,512,052.68	31,607,947.32	77.6
Урамшуулал	54,231,800.00	53,791,271.90	440,528.10	99.2
Нийгмийн хамгааллын шимтгэл	287,534,400.00	257,956,886.60	29,577,513.40	89.7
Тэтгэврийн шимтгэл	195,523,400.00	180,016,734.30	15,506,665.70	92.1
Тэтгэмжийн шимтгэл	23,002,700.00	22,652,062.10	350,637.90	98.5
ҮОМШӨ-ний даатгал	11,501,400.00	11,156,577.77	344,822.23	97.0
Ажилгүйдлийн даатгал	11,501,400.00	8,826,302.39	2,675,097.61	76.7
Эрүүл мэндийн даатгал	46,005,500.00	35,305,210.04	10,700,289.96	76.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,017,100.00	65,823,600.90	17,193,499.10	79.3
Гэрэл цахилгааны зардал	13,330,000.00	11,974,612.46	1,355,387.54	89.8
Түлш, халаалтын зардал	61,731,000.00	49,027,064.44	12,703,935.56	79.4
Цэвэр, бохир усны зардал	7,956,100.00	4,821,924.00	3,134,176.00	60.6
Хангамж, бараа материалын зардал	63,710,000.00	34,433,527.00	29,276,473.00	54.0
Бичиг хэргийн материал	4,210,000.00	2,539,150.00	1,670,850.00	60.3
Тээвэр, шатахууны зардал	12,400,000.00	262,400.00	12,137,600.00	2.1
Шуудан холбооны зардал	19,236,000.00	10,001,827.00	9,234,173.00	52.0
Хог хаягдал зайлуулах	660,000.00	348,000.00	312,000.00	52.7
Бага үнэтэй түргэн элэгдэх	27,204,000.00	21,282,150.00	5,921,850.00	78.2
Нормативд зардал	179,000,000.00	115,142,209.55	63,857,790.45	64.3
Хоол	166,000,000.00	106,442,209.55	59,557,790.45	64.1
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	13,000,000.00	8,700,000.00	4,300,000.00	66.9
Эд хогшил, урсгал засварын зардал	46,880,000.00	20,920,360.00	25,959,640.00	44.6
Багаж техник хэрэгсэл	13,600,000.00	10,081,360.00	3,518,640.00	74.1
Тавилга	2,000,000.00	1,800,000.00	200,000.00	90.0
Урсгал засварын зардал	31,280,000.00	9,039,000.00	22,241,000.00	28.9
Томилол, зочны зардал	9,100,000.00	820,000.00	8,280,000.00	9.0

Дотоод томилолтын зардал	9,100,000.00	820,000.00	8,280,000.00	9.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,005,000.00	1,339,713.20	4,665,286.80	22.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,005,000.00	1,339,713.20	4,665,286.80	22.3
Бараа үйлчилгээний бусад зардал	11,000,000.00	1,944,500.00	9,055,500.00	17.7
Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	304,500.00	2,095,500.00	12.7
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	8,600,000.00	1,640,000.00	6,960,000.00	19.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,229,400.00	53,975,057.00	70,254,343.00	43.4
Бусад урсгал шилжүүлэг	124,229,400.00	53,975,057.00	70,254,343.00	43.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67,479,400.00	44,313,057.00	23,166,343.00	65.7
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	56,750,000.00	9,662,000.00	47,088,000.00	17.0
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	3,110,750,900.00	2,801,028,800.11	309,722,099.89	90.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Татаас, санхүүжилтийн орлого	-	436,397,862.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	436,397,862.00
Нөөц сангаас	-	396,176,362.00
Орон нутгийн төсвөөс	-	40,221,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	-	436,397,862.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	436,397,862.00
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	-	421,954,114.30
Ажиллагчидтай холбогдсон зардал	-	331,378,214.30
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	-	296,742,990.21
Цалингийн тусгай нэмэгдлүүд	-	296,742,990.21
Нийгмийн хамгааллын шимтгэл	-	34,635,224.09
Тэтгэврийн шимтгэл	-	23,981,916.33
Тэтгэмжийн шимтгэл	-	2,967,429.89
ҮОМШӨ-ний даатгал	-	1,483,715.04
Ажилгүйдлийн даатгал	-	1,240,432.61
Эрүүл мэндийн даатгал	-	4,961,730.22
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	5,900,000.00
Түлш, халаалтын зардал	-	5,900,000.00
Нормативд зардал	-	32,474,000.00
Хоол	-	32,474,000.00
Хангамж, бараа материалын зардал	-	978,200.00
Тээвэр, шатахууны зардал	-	978,200.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	882,300.00
Урсгал засварын зардал	-	882,300.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	50,341,400.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	50,341,400.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	-	14,443,747.70
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	14,443,747.70

НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	-	436,397,862.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 977.6 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад 977.6 мянган төгрөгийн 1 алдааг залруулсан. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн тээвэр шатахууны зардлын дүнг өглөгийн тодруулга тайлангийн тээвэр шатахууны өглөгийн дүнтэй тулган баталгаажуулахад 977.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 46,822.5 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс 18,193.2 мянган төгрөгийн 2 зөрчилд алдаа зөрчлийг таслан зогсож, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 28,629.3 мянган төгрөгийн 3 зөрчилд хууль хэрэгжүүлэн ажиллах 3 зөвлөмж өгч ажилласан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 20,510.7 мянган төгрөгөөр их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт: 1 Зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдлээгүй нь анхан шатны баримтаар нотлогдохгүй нөхөн олговорт 18,095.2 мянган төгрөг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Засгийн газрын 2025 оны 05 албан даалгавартай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт: 2 Албан томилолтыг түүвэрлэн шалгахад албан хаагчдад 98.0 мянган төгрөгийн хоолны нөхөх төлбөрийг давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхиуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгө ашиглалтын бүртгэлийг тайлант хугацаанд шинэчилж баталгаажуулаагүй, эд хариуцагчийн гэрээ байгуулаагүй, үндсэн хөрөнгийг бүрэн коджуулаагүй.

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1, 71.1. 2 -д заасныг хэрэгжүүлж ажиллах.

Илрүүлэлт 2: Тайлант хугацаанд байгууллагын хөрөнгөөр 11,881.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн байгууллагын хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан авч хэвших.

Илрүүлэлт 3: Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 3 гүйлгээ буюу 16,747.9 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр мэдээлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдлээгүй нь анхан шатны баримтаар нотлогдохгүй нөхөн олговорт 18,095,160 төгрөг зарцуулсан	1	18,095.2			1	18,095.2						
Ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгө ашиглалтын бүртгэлийг тайлант хугацаанд шинэчилж баталгаажуулаагүй, эд хариуцагчийн гэрээ байгуулаагүй, үндсэн хөрөнгийг бүрэн коджуулаагүй.	1	-					1	-				
Албан томилолтыг түүвэрлэн шалгахад албан хаагчдад 98.0 мянган төгрөгийн хоолны нөхөх төлбөрийг давхардуулан олгосон	1	98.0			1	98.0						
Тайлант хугацаанд байгууллагын хөрөнгөөр 11,881.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	11,881.3					1	11,881.3				
Дүн	4	30,074.5			2	18,193.2	2	11,881.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 3 гүйлгээ буюу 16,747.9 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.	1	16,747.9						1	16,747.9
Дүн	1	16,747.9						1	16,747.9

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайлангийн тээвэр шатахууны зардлын дүнг өглөгийн тодруулга тайлангийн тээвэр шатахууны өглөгийн дүнтэй тулган баталгаажуулахад 977.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	977.6			1	977.6	1	977.6				
Дүн	1	977.6			1	977.6	1	977.6				